

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2014 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2014.11.07

Улаанбаатар хот

НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 91 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 3 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 351 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

2006 оны жилийн эцсийн тайлант хугацаанаас хойш ББСБ-уудын тоонд дараах өөрчлөлт орсон байна.

/Хүснэгт 1/

№	Тайлант хугацаа	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо	Үүнээс:		
			Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ
1	2006 он	139	-	-	-
2	2007 он	137	-	-	-
3	2008 он	132	23	11	-
4	2009 он	177	27	9	47
5	2010 он	182	26	15	48
6	2011 он	195	23	17	39
7	2012 он	212	24	17	38
8	2013 он	263	31	19	41
9	2014 оны III улирал	351	40	24	53

Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 2/

№	Тайлант хугацаа	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
1	2006 он	2	24	-	-	139
2	2007 он	10	12	-	-	137
3	2008 он	10	15	-	-	132
4	2009 он	56	11	15	9	177
5	2010 он	20	15	20	7	182
6	2011 он	32	19	14	8	195
7	2012 он	23	6	4	2	212
8	2013 он	54	3	3	1	263
9	2014 оны III улирал	91	3	3	1	351

2014 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 91 компанид 31,031,350.6 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон.

Тайлант хугацаанд Хорооны хуралдаанаар 3 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 3 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгон, 11 ББСБ-д тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны төрлийг нэмж олгосон.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:

/График 1/



ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 3/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо	
		2013 оны III улирал	2014 оны III улирал
1	Гадаад валютын арилжаа эрхэлдэг нийт	99	124
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	39	53
2	Зээл	203	296
3	Факторингийн үйлчилгээ	13	16
4	Төлбөрийн баталгаа гаргах	9	11
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	6
7	Итгэлцлийн үйлчилгээ	20	25
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	20	27

2014 оны гуравдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 351 ББСБ-ын 84.3 хувь нь зээл, 35.3 хувь нь гадаад валютын арилжаа /15.1 хувь нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг/, 7.7 хувь нь хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 1.7 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 4.5 хувь нь факторингийн үйлчилгээ, 3.1 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 7.1 хувь нь итгэлцлийн ББСБ-уудын 2014 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

үйлчилгээ, 0.6 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

2014 оны гуравдугаар улирлын байдлаар тайлан ирүүлбэл зохих нийт 351 ББСБ-аас 347 ББСБ буюу 98.9 хувь нь тайлангаа ирүүлснийг холбогдох журмын дагуу хянан тайлангийн нэгтгэлд хамруулсан болно.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Өмнөх оны мөн үеийн голлох статистик үзүүлэлтүүдийг 2014 оны гуравдугаар улирлын тайлант хугацаатай харьцуулж харуулбал: Үүнд

				/Хүснэгт 4/
№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны IY улирал	2014 оны III улирал	Өсөлт +/-, бууралт -/-
1	ББСБ-ын тоо	245	351	88
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	638	863	101
3	Ажиллагсадын тоо	1,343	1,632	236
4	Салбар нэгжийн тоо	76	92	8
5	Харилцагчдын тоо	533,016	518,489	14,527
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	344,064,023.00	489,991,180.90	145,927,157.9
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>1.89%</i>	<i>2.70%</i>	<i>0.81%</i>
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	209,591,331.5	293,922,125.60	84,330,794.1
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>2.06%</i>	<i>2.04%</i>	<i>-0.02%</i>
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	216,371,696.6	301,294,304.10	84,922,607.5
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>17.87%</i>	<i>24.90%</i>	<i>7.03%</i>
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	172,025,247.3	234,374,720.90	62,349,473.6
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>46.88%</i>	<i>58.70%</i>	<i>11.82%</i>
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	18,366,924.1	24,941,126.00	6,574,201.9
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	76,367,818.8	127,862,015.50	51,494,196.7
	Үүнээс: Богино хугацаат зээл/мянган төгрөгөөр/	51,129,333.5	72,160,008.10	21,030,674.6
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	25,238,485.3	55,702,007.40	30,463,522.1
12	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	11,128,560.7	11,829,385.90	700,825.2
13	Нийт орлого /мянган төгрөгөөр/	72,051,924.00	99,398,778.10	27,346,854.1
14	Нийт зардал /мянган төгрөгөөр/	51,006,795.00	72,446,935.30	21,440,140.3
15	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	21,014,753.6	26,705,079.50	5,690,325.9

2014 оны гуравдугаар улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив өмнөх оны мөн үеэс 42.4 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд хувь нийлүүлсэн хөрөнгө 62.3 тэрбум төгрөгөөр, тухайлвал тайлант хугацаанд шинээр тусгай зөвшөөрөл авсан 91 ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 31.0 тэрбум төгрөг, тайлант хугацаанаас өмнө тусгай зөвшөөрөлтэй байсан ББСБ-ууд нийт 31.3 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа

эзэмшигчдийн бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулсан буюу нэмэлт хөрөнгө оруулалт, хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн.

Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт актив 490.0 тэрбум төгрөг, зээлийн өрийн үлдэгдэл 293.9 тэрбум төгрөг, эзэмшигчдийн өмч 301.3 тэрбум төгрөг, дүрмийн сан 234.4 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын үзүүлэлтүүдтэй харьцуулахад нийт активын 2.7 хувьтай, зээлийн өрийн үлдэгдлийн 2.0 хувьтай, эзэмшигчдийн өмчийн 24.9 хувьтай, дүрмийн сангийн 58.7 хувьтай тус тус тэнцэж байна. ББСБ-д ажиллах боловсон хүчний тоо 1,632 /үүнээс эмэгтэй ажилчид 911/, харилцагчдын тоо 518,489-д хүрсэн байна. Харилцагчдын тооны бүтцийг авч үзвэл зээлдэгч 57 507, санхүүгийн түрээслэгч 660, факторингийн үйлчилгээнд хамрагдагсад 5, итгэлцлийн үйлчилгээнд 10 371, төлбөр тооцооны болон бусад үйлчилгээнд 450 061 үйлчлүүлэгч, харилцагчид тус тус хамрагдсан байна.

2014 оны гуравдугаар улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй 351 ББСБ байгаагийн 88.6 хувь буюу 311 ББСБ нь УБ хотод, 11.4 хувь буюу 40 ББСБ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

ББСБ-уудын байршлыг графикаар үзүүлбэл:

/график 2/



Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 311 ББСБ-ын байршлыг авч үзвэл Чингэлтэй дүүрэгт 115, Баянзүрх дүүрэгт 41, Сүхбаатар дүүрэгт 92, Баянгол дүүрэгт 43, Хан-Уул дүүрэгт 13, Налайх дүүрэгт 2, Багануур дүүрэгт 2 ББСБ тус тус байрлан үйл ажиллагаа явуулж байна.

2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2014 оны гуравдугаар улирлын байдлаар орон нутагт төвтэй 40 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 11.4 хувийг, тэдгээрийн актив нь нийт ББСБ-ын активын 2.0 хувийг, олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын зээлийн үлдэгдлийн 2.5 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 3.0 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 2.7 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

/Хүснэгт 5/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны III улирал	2014 оны III улирал	Өсөлт /+/, бууралт -/
---	--------------------	------------------------	------------------------	--------------------------

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	27	40	13
<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	11.02%	11.4%	0.38%
А Нийт актив /мянган төгрөгөөр/	7,041,230.0	9,786,548.5	2,745,318.5
<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	2.69%	2.0%	0.69%
Б Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	5,638,796.8	7,369,235.7	1,730,438.9
<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	2.69%	2.5%	-0.2%
Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	145,897.1	166,382.2	20,485.1
В Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	6,450,845.1	9,054,795.1	2,603,950.0
<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	2.98%	3.0%	0.02%
Г Нийт дүрмийн сан /хувьцаат капитал//мянган төгрөгөөр/	4,549,610.4	6,329,951.8	1,780,341.4
<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	2.64%	2.7%	0.1%

Хорооноос орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бичил санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх талаар орон нутаг дахь төлөөлөгчдөд зориулсан сургалт, семинарыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, иргэдэд чиглэсэн мэдээлэл, зөвлөгөөг бичил санхүүгийн газрын хянан шалгагч нар орон нутагт томилолтоор ажиллах хугацаандаа болон ажлын байранд, түүнчлэн телефон утсаар тухай бүрд нь заавар зөвлөмжийг өгч ажиллаж байгаагийн дүнд сүүлийн жилүүдэд орон нутагт үйл ажиллагаа явуулах ББСБ-ын тоо нэмэгдсээр байна.

Тухайлвал 2012 оны жилийн эцэст 24 ББСБ орон нутагт үйл ажиллагаа явуулж байсан бол 2013 оны жилийн эцэст 31, 2014 оны эхний 9 сарын байдлаар 40 ББСБ орон нутагт үйл ажиллагаа явуулж жил тутам 29 хувиар тооны хувьд өссөн үзүүлэлттэй байна.

Мөн УБ хотод төвтэй, үйл ажиллагаа явуулж буй 10 ББСБ нь хөдөө орон нутагт нийт 24 салбар нэгжийг байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

2014 оны гуравдугаар улирлын байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 24 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 6.8 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 14.5 хувийг, олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 15.0 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн 13.1 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 13.2 хувийг тус тус эзэлж байна.

№	Үндсэн үзүүлэлтүүд	/Хүснэгт 6/		
		2013 оны III улирал	2014 оны III улирал	Өсөлт /+/, бууралт -/
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	18	24	6
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	7.35%	6.84%	-0.51%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	49,852,656.0	70,888,798.8	21,036,142.8
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	14.49%	14.5%	0.02%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	32,931,577.6	43,983,707.3	11,052,129.7
	Үүнээс: Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	2,090,872.0	2,553,852.6	462,980.6
	<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	15.71%	15.0%	-0.7%
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	31,555,785.2	39,550,293.4	7,994,508.2
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	14.58%	13.1%	1.48%
Г	Нийт дүрмийн сан /мянган төгрөгөөр/	24,300,362.5	30,910,829.4	6,610,466.9
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	14.13%	13.19%	-0.94%

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 10, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 6, АНУ 2, Итали, ОХУ, БНХАУ, Люксембург, Малайз, Швейцар, Хонгконгийн хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:

Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 351 ББСБ-ын 124 ББСБ буюу 35.3 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагаас 53 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг давхар эрхлэн явуулж буй 124 ББСБ нь нийт ББСБ-ын 35.3 хувийг эзэлж байна.

Гадаад валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 53 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 15.1 хувийг, тэдгээрийн актив нийт ББСБ-ын активын 2.9 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчдийн өмчийн 3.7 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 4.1 хувийг тус тус эзэлж байна. Гадаад валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг харуулвал дараах байдалтай байна.

/Хүснэгт 7/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны III улирал	2014 оны III улирал	Өсөлт /+/, бууралт -/
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагааг эрхэлж буй ББСБ-ын тоо	39	53	14
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>15.92%</i>	<i>15.10%</i>	<i>-0.82%</i>
A	Нийт актив /мянган төгрөгөөр/	8,002,989.0	14,461,985.9	6,458,996.9
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>2.33%</i>	<i>2.95%</i>	<i>0.62%</i>
	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	7,838,876.4	11,263,138.7	3,424,262.3
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	<i>3.62%</i>	<i>3.74%</i>	<i>0.12%</i>
B	Нийт дүрмийн сан /мянган төгрөгөөр/	6,479,692.4	9,546,742.4	3,067,050.0
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	<i>3.77%</i>	<i>4.07%</i>	<i>0.3%</i>

ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**3.1 Активын бүтэц, өөрчлөлт:**

Тайлант жилд нийт ББСБ-уудын активын бүтэц өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 8/

№	ХӨРӨНГӨ	2013.9.30		2014.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %
A	Эргэлтийн хөрөнгө	333,150,202.80	96.83	473,360,973.10	96.6	140,210,770.30	42.1
1	Мөнгөн хөрөнгө	95,234,327.59	27.68	145,301,129.90	29.6	50,066,802.31	52.6
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	9,839,961.66	2.86	10,874,907.20	2.2	1,034,945.54	10.5
3	Нийт зээл	209,591,331.55	60.92	293,922,125.60	60	84,330,794.05	40.2
	(Зээлийн эрсдлийн сан)	6,100,364.82	1.77	12,414,972.40	2.5	6,314,607.58	1.0 дахин
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	81.35	0.00	8,235.60	0	8,154.25	100.2 дахин
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	-	-	-	-	-	-
5	Нийт факторингийн тооцооны авлага	808,620.00	0.24	74,800.00	0.02	-733,820.00	-90.7
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	1,500.00	0.00	1,500.00	0	0.00	0.0
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	833,310.56	0.24	1,569,183.40	0.3	735,872.84	88.3

7	Бусад хөрөнгө	22,944,434.92	6.67	34,027,063.70	6.9	11,082,628.78	48.3
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага	-	-	-	-	-	-
Б	Эргэлтийн бус хөрөнгө	10,913,820.00	3.17	16,630,207.90	3.4	5,716,387.90	52.4
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	10,913,820.00	3.17	16,630,207.90	3.4	5,716,387.90	52.4
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	14,435,809.06	4.20	21,166,505.80	4.3	6,730,696.74	46.6
	(Хуримтлагдсан элэгдэл)	3,521,989.06	1.02	4,536,298.30	0.9	1,014,309.24	28.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		344,064,023.00	100.0	489,991,180.90	100.0	145,927,157.90	42.4

2014 оны гуравдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 351 ББСБ нь 489,991,180.9 мянган төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба активын өсөлт нь өмнөх оны мөн үеэс 145,927,157.9 мянган төгрөгөөр буюу 42.4 хувиар өссөн байна.


Активын өсөлтийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 3/



Тайлант хугацаанд нийт активын 96.6 хувь нь эргэлтийн хөрөнгө, 3.4 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байх ба өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 4/



Эргэлтийн хөрөнгийн 30.7 хувь буюу 145,301,129.9 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгө эзэлж байгаа ба мөнгөн хөрөнгийн 42.8 хувийг бэлэн мөнгө, 57.2 хувийн банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж эзэлж байна.

3.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 9/


№	Ангилал	2013.9.30		2014.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %
1	Хэвийн	193,169,905.9	92.2	256,784,754.2	87.4	63,614,848.3	32.9
2	Хугацаа хэтэрсэн	6,795,808.1	3.2	19,304,909.1	6.6	12,509,101.0	184.1
3	Чанаргүй зээл. Үүнээс	9,625,617.5	4.6	17,832,462.3	6.1	8,206,844.8	85.3
	Хэвийн бус	3,749,532.2	1.8	5,099,022.6	1.7	1,349,490.4	36.0
	Эргэлзээтэй	2,153,287.7	1.0	6,837,220.0	2.3	4,683,932.3	217.5
	Муу	3,722,797.6	1.8	5,896,219.7	2.0	2,173,422.1	58.4
	(Зээлийн эрсдлийн сан)	6,100,364.8	2.9	12,414,972.4	4.2	6,314,607.6	103.5
	Нийт зээл	209,591,331.5	100.0	293,922,125.6	100.0	84,330,794.1	40.2
	Үүнээс: Гадаад валютаар олгосон зээл	25,001,068.6	11.9	39,546,390.6	13.5	14,545,322.0	58.2

2014 оны гуравдугаар улирлын байдлаарх зээлийн үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн хэмжээ 84,330,794.1 мянган төгрөгөөр буюу 40.2 хувиар нэмэгдсэн байх ба нийт зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээл 1.8 дахин, чанаргүй зээлийн эзлэх хувь 85.3 хувиар өссөн байна. Зээлийн ангилал дахь чанаргүй зээлийн эзлэх хувь 36.0-с 2.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацааны нийт зээлийн үлдэгдлийн 13.5 хувь буюу 39,546,390.6 мянган төгрөгийн зээлийг валютаар олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

/График 5/



Тайлант хугацаанд 296 ББСБ нь Хорооноос банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт 293,922,125.6 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байгаагаас 17,832,462.3 мянган төгрөг буюу 6.1 хувийг чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байна.


2014 оны эхний 9 сарын байдлаарх зээлийн чанарыг өмнөх онуудтай харьцуулахад нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь сүүлийн 3 жилийн дунджаас 1.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.3 Зээлийн хүү:

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 326 ББСБ-аас 84.0 хувь буюу 296 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба эдгээр компаниудын зээлийн сарын хамгийн дээд хүү 10.0 хувь, хамгийн бага хүү 0.5 хувь байна.

ББСБ-уудын зээлийн сарын дундаж дээд хүү 4.2 хувь, зээлийн дундаж доод хүү 2.4 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 3.3 хувьтай байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.



3.4 Активын бусад үзүүлэлтийн талаар:

Тайлант хугацаанд богино хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэлд 10,899,334.0 мянган төгрөг /цэврээр 10,874,907.3 мянган төгрөг/ байх ба үүний 0.5 хувь нь буюу 61,154.9

мянган төгрөг нь арилжааны үнэт цаас, 99.7 хувь нь буюу 10,838,179.1 мянган төгрөг нь хөрөнгө оруулалтын үнэт цаас тус тус эзэлж, түүнд ногдох 24,426.7 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

/Хүснэгт 10/

№	Богино хугацаат хөрөнгө оруулалтын төрөл	Хэмжээ /мянган төгрөг/	Богино хугацаат хөрөнгө оруулалтад эзлэх хувь
1	Арилжааны үнэт цаас	61,154.9	0.5%
2	Хөрөнгө оруулалтын үнэт цаас	10,838,179.1	99.7%
3	Эрсдэлийн сан	-24,426.7	/0.2%/
	Нийт	10,874,907.3	100.0%

Богино хугацаат хөрөнгө оруулалтын дансанд бүртгэгдсэн актив хөрөнгийн 1.2 хувь нь буюу 134,554.8 мянган төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалтын тухайд Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын:

- 2-г “Таван толгойн нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэс-Таван толгой” компанийн хувьцааны 50 хүртэлх хувийг Монгол Улсын иргэн, үндэсний аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэх, дотоод, гадаадын хөрөнгийн биржээр арилжаалах талаар дараахь арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэх:
- 2.б-д “хувьцааны 10 хүртэлх хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдах...”-

-ыг Монгол Улсын Засгийн газарт даалгасны дагуу худалдан авч бүртгэлд тусгасан нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр хийгдсэн үйл ажиллагаа юм.

Харин богино хугацаат хөрөнгө оруулалтын дансанд бүртгэгдсэн актив хөрөнгийн 13.9 хувь нь буюу 1,507,652.5 мянган төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалтын хувьд Санхүүгийн зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгоогүй бөгөөд энэ нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12.1-д заасан “Банк бус санхүүгийн байгууллага дараахь үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно: 12.1.1. тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх” гэсэн заалтыг зөрчин банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлд хамаарагдахгүй үйл ажиллагаа явуулсан байна.

Мөн богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй боловч Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4.1.8-д заасан “Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх” гэж тодорхой гэрээний үндсэн дээр иргэн хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг нэг жил хүртэлх хугацааны хөрөнгө оруулалтын үнэт цаас болон үүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэхийг” хэмээн тодорхойлсныг зөрчин хуулийн этгээдүүдээс 9,232,700.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг 1 жилээс дээш хугацаагаар гэрээ хийсэн тохиолдол байна.

Иймд холбогдох хууль тогтоомжийг зөрчин үйл ажиллагаа явуулж буй зөрчилтэй ББСБ-уудад зохих хуулийн дагуу хяналт тавин, захиргааны арга хэмжээ авч, шалгалтын тайлангаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

Факторингийн тооцооны авлагад 74,800.0 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэн байх ба 59.9 хувь нь хэвийн, 40.1 хувь нь хугацаа хэтэрсэн авлагад ангилагдан 1,500.0 мянган төгрөгийн эрсдэлийн сан үүсгэсэн байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 351 ББСБ-д 16,630,207.87 мянган төгрөгийн үндсэн ба биет бус хөрөнгө /цэврээр/ бүртгэгдэн ба тэдгээрт 4,536,297.98 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэн тооцон нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

Зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг нийт 296 ББСБ-аас зээл, эргэн төлөлтийн талаарх судалгаанд 190 ББСБ нь буюу 64.2 хувь нь хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан ББСБ-уудад тайлант хугацаанд 294,731.8 сая төгрөгийн зээл олгож, 244,587.3 сая төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна.

Харин тайлант хугацаанд тайлан ирүүлбэл зохих нийт 351 ББСБ-аас 347 ББСБ тайлангаа ирүүлсний дотор гадаадын даатгалын байгууллагад даатгагдсан ББСБ байхгүй байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

2014 оны тайлант хугацаанд ББСБ-уудын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.


/Хүснэгт 11/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2013.9.30		2014.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %	Дүн /мян.төг/	Хувь %
А	Өр төлбөр	109,567,858.8	31.8	171,514,859.6	35.0	61,947,000.8	56.5
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	18,366,924.1	5.3	24,941,126.0	5.1	6,574,201.9	35.8
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	76,367,818.8	22.2	127,862,015.5	26.1	51,494,196.7	67.4
3	Бусад эх үүсвэр	2,511,755.1	0.7	5,046,932.1	1.0	2,535,177.0	1.1 дахин
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	3,949.6	0.0	53,517.2	0.01	49,567.6	12.5 дахин
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	2,507,727.2	0.7	4,993,415.0	1.0	2,485,687.8	99.1
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	78.2	0.0	-	-	-	-
	Факторингийн үйлчилгээний өглөг	-	-	-	-	-	-
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	-	-	-
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	1,192,800.0	0.3	1,835,400.0	0.4	642,600.0	53.9
5	Төслийн зээлийн санхүүжилт	11,128,560.7	3.2	11,829,386.0	2.4	700,825.3	6.3
	Бусад өр төлбөр	18,124,467.4	5.3	17,182,017.2	3.5	-942,450.2	-5.2
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,518,427.1	0.7	3,492,243.5	0.7	973,816.4	38.7
7	Бусад пассив	15,606,040.3	4.5	13,689,773.7	2.8	-1,916,266.6	-12.3
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	-	-	-	-	-	-
	Нийт өр төлбөр	127,692,326.2	37.1	188,696,876.8	38.5	61,004,550.6	47.8
Б	Эзэмшигчдийн өмч	216,371,696.6	62.9	301,294,304.1	61.5	84,922,607.5	39.2
9	Хувьцаат капитал	172,025,247.3	50.0	234,374,720.9	47.8	62,349,473.6	36.2
10	Бусад өмч	7,749,272.0	2.2	7,848,251.1	1.6	98,979.1	1.3
11	Сангууд	186,341.9	0.1	299,947.0	0.1	113,605.1	61.0
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	33,980,365.8	9.9	56,979,175.1	11.6	22,998,809.3	67.7
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	2,430,469.5	0.7	1,792,209.9	0.4	-638,259.6	-26.3
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	344,064,023.0	100.0	489,991,180.9	100.0	145,927,157.9	42.4

2014 оны гуравдугаар улирлын байдлаар нийт эх үүсвэрийн 38.5 хувийг нийт өр төлбөр, 61.5 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 47.8 хувиар, эзэмшигчдийн өмч 39.2 хувиар тус тус өссөн байна.

ББСБ-уудын системийн нийт пассивын хэмжээг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.


/График 7/



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл 67.4 хувиар, төслийн зээлийн санхүүжилтийн хэмжээ 6.3 хувиар, бусад эх үүсвэр 1.1 дахин өссөн байна.

Тайлант хугацаанд шинээр байгуулагдсан банк бус санхүүгийн байгууллагуудын тоо өмнөх онтой харьцуулахад 68.5 хувийн өсөлттэй байгаа бөгөөд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэйгээр ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр өсөхөд голлох нөлөө үзүүлж байна.

/График 8/



2014 оны гуравдугаар улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 25 ББСБ байгаагаас нэр бүхий 18 ББСБ нь итгэлцлээр 24,941,126.0 мянган төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байх ба эдгээр нь нийт ББСБ-ын 5.1 хувийг, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын нийт актив нь нийт ББСБ-ын активын 41.3 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 33.0 хувийг тус тус эзэлж байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 6 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 2014 оны гуравдугаар улирлын тайлант хугацаанд тэдгээрт 4,993,415.0 мянган төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг бүртгэлтэй байна.

Тайлант хугацаанд Хорооны зөвшөөрөлтэйгөөр 3 ББСБ-д нийт 1,835,400.0 мянган төгрөгийн хаалттай өрийн бичгийн, 10 ББСБ-д 1,792,209.9 мянган төгрөгийн хоёрдогч өглөг тус тус бүртгэгдсэн байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

ББСБ-уудын 2014 оны гуравдугаар улирлын байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 38.0 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 12/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.9.30		2014.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь %	Дүн /мянган төгрөг/	Хувь %	Дүн /мянган төгрөг/	Хувь %
1	ХҮҮГИЙН ОРЛОГО	46,203,470.3	64.1	65,510,258.9	65.9	19,306,788.6	41.8
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	44,738,304.6	62.1	62,582,339.2	63.0	17,844,034.6	39.9
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	830,022.6	1.1	2,231,978.8	2.2	1,401,956.2	1.7 дахин
	Үнэт цаасны хүүгийн орлого	-	-	-	-	-	-
	Бусад хүүгийн орлого	635,143.1	0.9	695,940.8	0.7	60,797.7	9.6
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	24,868,545.30	34.5	32,878,580.2	33.1	8,010,034.9	32.2
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	878,128.10	1.2	932,131.0	0.9	54,002.9	6.1
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	101,780.30	0.1	77,808.0	0.1	-23,972.3	-23.6
	НИЙТ ОРЛОГО	72,051,924.00	100.0	99,398,778.10	100.0	27,346,854.1	38.0

Тайлант хугацааны нийт орлогын 65.9 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 41.8 хувиар өссөн/, 33.1 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 1.7 дахин өссөн/ эзэлж байна.

Хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 32.2 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 13/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.9.30		2014.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь %	Дүн /мянган төгрөг/	Хувь %	Дүн /мянган төгрөг/	Хувь %
1	Арилжааны орлого	3,772,613.4	15.2	3,401,341.2	10.3	-371,272.2	-9.8
1.1	Гадаад валютын арилжааны орлого	3,772,268.0	15.2	3,242,241.0	9.9	-530,027.0	-14.1
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	345.4	0.0	159,100.1	0.5	158,754.7	459.6
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	16,932,532.3	68.1	23,915,943.2	72.7	6,983,410.9	41.2
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	15,980,800.0	64.3	22,783,917.5	69.3	6,803,117.5	42.6
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	951,732.2	3.8	1,132,025.7	3.4	180,293.5	18.9
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	4,163,399.6	16.7	5,647,568.5	17.2	1,484,168.9	35.6
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	842.0	0.0	789.5	0.0	-52.5	-6.2

3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	-	-	8,287.4	0.0	-	-
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	535,889.4	2.2	665,532.7	2.0	129,643.3	24.2
3.4	Картын үйлчилгээний орлого	-	-	1,510.0	0.0	-	-
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	397,276.1	1.6	517,213.2	1.6	119,937.1	30.2
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	2,804,804.0	11.3	4,023,955.0	12.2	1,219,151.0	43.5
3.7	Бусад	424,588.1	1.7	431,854.0	1.3	7,265.9	1.7
	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ	24,868,545.3	100.0	32,878,580.2	100.0	8,010,034.9	32.2

2014 оны гуравдугаар улирлын байдлаар нийт хүүгийн бус орлогын 9.9 хувийг гадаад валютын арилжааны орлого, 72.7 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 17.2 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/Хүснэгт 14/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.9.30		2014.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь %	Дүн /мянган төгрөг/	Хувь%	Дүн /мянган төгрөг/	Хувь %
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	6,169,345.7	12.1	9,556,215.4	13.2	-15,725,561.1	54.9
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	38,569,482.1	75.6	51,443,992.8	71.0	-90,013,474.9	33.4
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	2,808,608.3	5.5	7,385,617.9	10.2	-10,194,226.2	163.0
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	874,392.7	1.7	720,994.8	1.0	-1,595,387.5	-17.5
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	15,360.1	0.0	1,018.2	0.0	-16,378.3	- 93.4
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	2,569,606.1	5.0	3,339,096.2	4.6	-5,908,702.3	29.9
	НИЙТ ЗАРДАЛ	51,006,795.0	100.0	72,446,935.3	100.0	-123,453,730.3	42.0

Тайлант хугацаанд нийт зардал өмнөх оны мөн үеэс 42.0 хувиар өссөнөөс хүүгийн зардал 54.9 хувиар, хүүгийн бус зардал 33.4 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 1.6 дахин, орлогын татварын зардал 29.9 хувиар тус тус өсч харин үндсэн бус үйл ажиллагааны зардал 17.5 хувиар, ердийн бус зардал 93.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


2014 оны гуравдугаар улирлын байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 38.0 хувиар, нийт зардал 42.0 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд нийт 26,705,079.5 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26.9 хувиар өссөн байна.

/Хүснэгт 15/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2013.9.30	2014.9.30	Өөрчлөлт
		Дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/
1	НИЙТ ОРЛОГО	72,051,924.0	99,398,778.10	27,346,854.1
2	НИЙТ ЗАРДАЛ	51,006,795.0	72,446,935.3	21,440,140.3
	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	21,045,129.0	26,705,079.5	5,659,950.5

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна. /График 9/



ЗУРГАА. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 285,238,141.5 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 341,745,321.2 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын хувьд 82.4% хувь, өөрийн хөрөнгийн хувьд 84.7% хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 57.6% хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 13,175,338.7 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 300,875,365.2 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 4.38% хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 24,941,126.04 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 300,927,264.7 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа 8.29% хувь;

- нийт зээлийн өрийн үлдэгдэл 293,922,125.6 мянган төгрөг, үүнээс чанаргүй зээл 17,832,462.3 мянган төгрөг байгаагаас нийт зээл чанаргүй зээлийн харьцаа 6.1 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 8,219,468.1 мянган төгрөг, нийт актив 480,394,517.5 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.71% хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 11,869,047.4 мянган төгрөгөөр байгуулбал зохицоо 879,401.6 мянган төгрөгөөр илүү буюу нийт 12,748,449.0 мянган төгрөгөөр байгуулсан байна.¹

¹ Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.

ББСБ-уудын 2014 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

ДОЛОО. ДҮГНЭЛТ

1. 2014 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 351 ББСБ-аас 347 ББСБ буюу 98.9 хувь нь тайлангаа ирүүлсэн ба 21 ББСБ буюу 5.6 хувь нь эхлэлтийн санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдсан байна.
2. ББСБ-уудын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 145,927,157.9 мянган төгрөг буюу 42.4 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 84,330,794.1 мянган төгрөг буюу 40.2 хувь, эзэмшигчдийн өмч 84,922,607.5 мянган төгрөг буюу 39.2 хувь, нийт дүрмийн сан 62,349,473.6 мянган төгрөг буюу 36.2 хувиар тус тус өссөн.
3. ББСБ-уудын нийт актив 2014 оны гуравдугаар улирлын байдлаар 489,991,180.9 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активтай харьцуулахад 2.7 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 293,922,125.6 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлтэй харьцуулахад 2.0 хувь, нийт дүрмийн сан 234,374,720.9 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт дүрмийн сантай харьцуулахад 58.7 хувьтай тус тус тэнцэж байна.
4. Зээлийн мэдээллийн тухай хууль 2011 оны 10 дугаар 20-ны өдөр батлагдан гарснаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар зөвшөөрсөн байгууллага зээлийн мэдээллийн сантай байхаар хуульчилсны дагуу тайлант улиралд нийт 169 ББСБ Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан, зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглаж байгаа нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх 296 ББСБ-ын 48.1 хувийг эзэлж байна.
5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Хорооны 2009 оны 253 дугаар тогтоолоор баталсан “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-д заасны дагуу нийт ББСБ-ын 85.5 хувь буюу 300 ББСБ нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журам”-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, 96.0 хувь буюу 337 ББСБ дээрх хуулийн хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих үүрэг бүхий ажилтныг томилон ажиллуулж байна.
6. 2014 онд Хороонд төвлөрүүлбэл зохих нийт 263 ББСБ-ын 258,782.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөгдөхөөс 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 261 ББСБ-ын 253,292.0 мянган төгрөгийг Хорооны дансанд төвлөрүүлсэн нь 97.9 хувьтай байна.
7. Нийт 263 ББСБ нь Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитаар баталгаажуулах хуулийн хариуцлагатайгаас 100.0 хувь буюу 263 ББСБ санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулан Хороонд ирүүлсэн.
8. Бичил санхүүгийн хөгжлийн сангаас дамжуулан зээлдүүлэх сонгон шалгаруулалтад 39 ББСБ-ын санхүүгийн үзүүлэлтүүдийн талаарх судалгаа хийгдсэн бөгөөд 2014 оны гуравдугаар улирлын байдлаар 11,829.4 сая төгрөгийн төслийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.

НАЙМ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛБЭЛ ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭ

Тус газраас дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

1. Тайлант хугацаанд ирүүлвэл зохих тайлан, мэдээг ББСБ-даас бүрэн авч, нэгтгэлд бүрэн хамруулах;
2. УИХ-аас 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр батлан гаргасан Зээлийн мэдээллийн тухай хуулийн 9.1.7-д “Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээг байгуулж,

мэдээлэл солилцох үүрэг хүлээх” гэсэн заалтын дагуу ББСБ-уудыг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах;

3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Хорооны 2009 оны 253 дугаар тогтоолоор баталсан “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ын 7.1-д Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд дотоод хяналтын хөтөлбөрийг баталж мөрдөх бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журам”-ын хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих үүрэг бүхий ажилтныг томилж ажиллуулна... гэсэн заалтын дагуу ББСБ-уудын холбогдох хууль, журмын хэрэгжилтэд байнга хяналт тавин ажиллах;
4. Үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, санхүү, төлбөрийн чадварыг тогтворжуулах, хууль, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ББСБ-уудын удирдлага, ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулах, сургалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР